

**УЛСЫН ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТОД ХҮН, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ
ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ**
SOME ISSUES TO BE CONSIDERED WHEN ENTERING PEOPLE AND
VEHICLES INTO STATE-IMPORTANT FACILITIES

Г.МЭНДБАЯР

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн
Дотоодын цэргийн албаны тэнхимийн ахлах багш, хошууч
Department of Internal Troops Service of the Police School,
University of Internal Affairs Mongolia Senior Lecturer, Major
Mendbayar. G

Хураангуй: Улсын онц чухал объектууд нь улс орны аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийн тогтвортой байдал, стратегийн чухал үйл ажиллагаатай холбоотой байдаг учраас эдгээр объектын хамгаалалт нь олон талын ач холбогдолтой.

Улсын онц чухал объектын хамгаалалтыг Монгол Улсын хууль, тогтоомж дүрэм заавар, стандартаар зохион байгуулж, хамгаалалтын чанарыг дээшлүүлж Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах шалган нэвтрүүлэх нэгдсэн стандарт болон хамгаалалтад хүнийг шалган нэвтрүүлэх ажиллагаа сайжруулах талаар энэхүү өгүүлэлд авч үзсэн болно.

Abstract: Since nationally important objects are related to the country's security, economic and social stability, and important strategic activities, the protection of these objects is of great importance in many ways.

This article discusses how to organize the protection of nationally important objects in accordance with Mongolian laws, regulations, instructions, and standards, improve the quality of protection, and improve the unified screening standards and personnel screening for protection to ensure the security of nationally important objects.

Түлхүүр үгс: Улсын онц чухал объект, гэмт хэрэг, зөрчил, аюулгүй байдал, объект, хамгаалалт

Keywords: State-important objects, crime, violation, security, object, protection,

Оршил хэсэг. Дотоодын цэргийн анги байгууллага, алба хаагчид хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд улсын онц чухал объектын хэвийн ажиллагааг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалж байгаа объектод нэвтрэх хүн, эд зүйл, тээврийн хэрэгслийг шалгах, хамгаалалтын бүсэд тогтоосон дэглэм, журмыг сахиулах цогц үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Иймд алба хаагч бүр хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Улсын онц чухал объектын хамгаалалтанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлүүд, аюулгүй байдлыг хангах, үүрэг гүйцэтгэлтэнд хууль, тогтоомж дүрэм заавар, стандартын дагуу зөрчил дутагдал гаргахгүй байх гол шаардлага гарч байна.

Үндсэн хэсэг

Дотоодын цэргийн тухай хуульд зааснаар Дотоодын цэрэг анги байгууллага улсын онц чухал объектыг хамгаалах зорилгоор дараах үүргийг гүйцэтгэдэг байна. Үүнд:

- улсын онц чухал объектод нэвтрүүлэх хүн, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, эд зүйлийг шалгах, бүртгэх;
- эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тогтоосон дүрэм, шалган нэвтрүүлэх журмыг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих;¹ чиг үүрэгтэй байдаг байна.

¹ Дотоодын цэргийн тухай хууль 12 дугаар зүйл 12.1.1, 12.1.2. дэх хэсэг 2017 оны 2 дугаар сарын 19-ний өдөр

Мөн Хамгаалж байгаа объектын хэвийн үйл ажиллагаа алдагдсан, зөрчил илэрсэн үед объектын захиргаа, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага болон бусад анги, салбартай мэдээлэл солилцох, тэдгээрийн хүч хэрэгслийг ашиглах, объектын онцлогт тохирсон шалган нэвтрүүлэх журмыг анги, салбарын захирагч холбогдох байгууллагатай зөвшилцөн тогтооно² гэж тодорхойлжээ.

Улсын онц чухал объектын хэвийн ажиллагааг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалж байгаа объектод нэвтрэх хүн, эд зүйл, тээврийн хэрэгслийг шалгах, хамгаалалтын бүсэд тогтоосон дэглэм, журмыг сахиулах цогц үйл ажиллагааг “объектын хамгаалалт”³ гэж тус тус тодорхойлсон байна.

Монгол улсын засгийн газрын 283 дугаар тогтоолоор батлагдсан Дотоодын цэргийн алба алба-ажиллагааны дүрэмд⁴ зааснаар тодорхой объектод хүн, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, тогтоосон дэг журмыг сахиулахаар томилсон зэвсэглэсэн салбарыг “объектыг хамгаалах харуул” гэж тодорхойлсон байна.

Дотоодын цэргийн алба алба-ажиллагааны дүрмийн 8 дэх хэсэгт зааснаар Объектыг хамгаалах харуулын албанд ажиллах харуулын дарга дараах үүрэг хүлээдэг. Үүнд:

- объектод шалгаж нэвтрүүлэх журмын биелэлтэд хяналт тавьж, шаардлагатай бол шалган нэвтрүүлэх харуулчин нэмж томилон ажиллуулах.

Хамгаалж байгаа объектын хэвийн ажиллагаа алдагдсан болон зөрчил гарсан тохиолдолд харуулын дарга дараах үүрэг хүлээх үүрэгт, харуулын цэгт үүрэг гүйцэтгэж байгаа шалган нэвтрүүлэгч-харуулчин, харуулчин (цагийн манаач)-д нэмэлт үүрэг өгөх гэж заасан байна.

Хамгаалж байгаа объектын онцлогт тохирсон “Объект хамгаалах харуулын заавар”-ыг ангийн захирагч, бие даан алба ажиллагаа явуулж байгаа салбар, салааны “Объект хамгаалах харуулын заавар”-ыг Штабын дарга тус тус батална. Объект хамгаалах харуулын зааварт харуулын даргын мөрдөх заавар, харуулчин (цагийн манаач)-ы үүрэг, ажиллах журам, холбоо, дохиолол, гэрэлтүүлгийн хэрэгслийг ашиглах журам, онцгой анхаарах хэсэг, гал, усны болон гэнэтийн бусад аюул осол гарах, зөрчил илэрсэн үед ажиллах, объектод үзлэг явуулах, хүн, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх журам зэргийг тусгадаг байна.

Дотоодын цэргийн алба алба-ажиллагааны дүрмийн 9 дэх хэсэгт зааснаар Объектод хүн, тээврийн хэрэгслийг шалгаж нэвтрүүлэх журмыг анги, салбарын захирагч объектын захиргаатай хамтран батлах бөгөөд журамд дараах зүйлийг тусгадаг⁵ байна. Үүнд:

- объектод нэвтрэх үнэмлэхийн ангилал, түүнийг олгох, хэрэглэх, хадгалах журам;
- объектод хүн, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх болон ачаа тээш, эд зүйл оруулах, гаргах журам;
- объектын захиргаа, шалган нэвтрүүлэгч-харуулчны хүлээх үүрэг;
- объектод үйлдвэрлэлийн осол, гал түймэр гарсан үед түргэн тусламж, галын болон ослын дуудлагаар ирсэн автомашиныг нэвтрүүлэх журмыг тус тус тусгаж өгдөг байна.

Объектод хүн, тээврийн хэрэгслийг шалгаж нэвтрүүлэх журмыг шалган нэвтрүүлэгч-харуулчин хэрэгжүүлдэг⁶ байна.

Мөн объектын хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байгаа харуулчин нь Улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагааны стандарт /CS 11-0129:2017/-д заасны дагуу дараах эрхтэй байдаг байна.

² Дотоодын цэргийн тухай хууль 12 дугаар зүйл 12.2. дэх хэсэг 2017 оны 2 дугаар сарын 19-ний өдөр

³ Дотоодын цэргийн тухай хууль 4 дүгээр зүйл 4.1.4 дэх хэсэг 2017 оны 2 дугаар сарын 19-ний өдөр

⁴ Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрэм 2 дэх хэсгийн 2.1.8 дэх заалт Монгол улсын засгийн газрын 283 дугаар тогтоол 2017 оны 9 дугаар сарын 27-ний өдөр

⁵ Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрэм 9 дэх хэсгийн 9.1. дэх заалт Монгол улсын засгийн газрын 283 дугаар тогтоол 2017 оны 9 дугаар сарын 27-ний өдөр

⁶ Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрэм 9 дэх хэсгийн 9.2. дэх заалт Монгол улсын засгийн газрын 283 дугаар тогтоол 2017 оны 9 дугаар сарын 27-ний өдөр

1. Объектод нэвтрэн орох хүмүүсийн үнэмлэх, нэвтрэх бичгийг шалгахдаа дараах стандартыг баримтална.⁷ Үүнд:

- Нэвтрэх үнэмлэх бичиг баримтыг үзэж шалгана;
- Үнэмлэх баримт бичгийн зураг, бичвэр зөв эсэх, хугацаа, тамга, гарын үсэг зэргийг шалгаж үзнэ;
- Шалгалтын явцад хяналтын асуулт тавьж, хариулт нь баримт бичигт бичигдсэнтэй тохирч байгаа эсэхийг шалгана;
- Зөрчлийг илрүүлж, таслан зогсоох, саатуулна.


2. Ачаа тээшинд үзлэг хийх:

- Ачаа тээшинд үзлэг хийхдээ эзнийг нь байлцуулна;
- Ачаа тээшинд байгаа эд зүйлсийн тоо ширхэг, төрөл, нэрсийг, жагсаалтын дагуу шалгана;
- Хүний цүнх, тээшинд үзлэг хийнэ.


3.Тээврийн хэрэгсэлд үзлэг хийх

- Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийг унтрааж, жолоочийг авто машинаас буулгана;
- Шаардлагатай тохиолдолд авто машины эд анги, нэмж тоноглогсон зүйлсийг салгаж шалгана гэж тус тус хамгаалалтанд тавигдах шаардлага байгууллагын стандартад нарийвчлан зааж өгчээ.

Дотоодын цэргийн анги байгууллагын алба хаагчдын шалган нэвтрүүлэх үйл ажиллагаагаар илрүүлсэн зөрчлийн судалгаа



Зөрчлүүдийн дийлэнх хувийг, объектод тогтоосон дэг журам зөрчсөн, болон баримт бичгийн зөрчлүүд эзэлж байгаа ба алба хаагчдаас илрүүлсэн хэлбэрийг авч үзэхэд шалган нэвтрүүлэх байранд үйл ажиллагаа явуулж байхад ажлын цагаар ихэвчлэн зөрчлүүд гардаг байна.



⁷ Улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагааны стандарт /CS 11-0129:2017/-ын 6.3.3. дэх заалт

Алба хаагчид улсын онц чухал объектод хамгаалалтын үүрэг гүйцэтгэх үед илрүүлсэн гэмт хэрэг, зөрчлүүдийн ихэнх хувийг, объектод тогтоосон дэг журам зөрчсөн, болон баримт бичгийн зөрчлүүд эзэлж байгаа ба алба хаагчдаас илрүүлсэн хэлбэрийг авч үзэхэд шалган нэвтрүүлэх байранд үйл ажиллагаа явуулж байхад ажлын цагаар ихэвчлэн зөрчлүүд гардаг байна.

Мөн Объектод хүн шалган нэвтрүүлэх тогтоосон дэг журмуудыг хэрэгжүүлэхэд дараах хүндрэлтэй бэрхшээлүүд үүсдэг байна. Жишээ нь:

1. Объектын бүсэд үйл ажиллагаа явуулдаг хувийн байгууллагуудад журам хэрэгжүүлэхэд ойлгомжгүй байдал үүсдэг байна. Шалган нэвтрүүлэх журам өөр байгууллагууд дагаж мөрдөх эрх зүйн үндэслэл байхгүй.
2. Объектын ажилтан алба хаагч нарт тогтоосон дэг журам зөрчсөний улмаас хуулийн хариуцлага тооцох эрх зүйн үндэслэл үүсэхгүй байна.
3. Объектод гадаадын иргэн шалган нэвтрүүлэх журмын дагуу гадаадын иргэдийг шалган нэвтрүүлэхэд хамгаалуулагч байгууллага хамгаалагч байгууллагын хооронд хүндрэл учирдаг байна. Энэ нь гадаадын иргэдийн хувьд эвгүй сэтгэгдэл төрж байна.

ДҮГНЭЛТ

Дээрхээс үзэхэд хамгаалуулж байгаа байгууллагын захиргаанаас тухайн байгууллагын нутаг дэвсгэрт дагаж мөрдөхөөр тогтоосон дэглэм журам, байгаа эсэхийг тодотгож эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр баталгаажуулж мөрдүүлэх.

Хамгаалуулагч байгууллагын захиргаа нь өөрийн байгууллагын нутаг дэвсгэрт дагаж мөрдөхөөр тогтоосон дэглэмийг байгууллагын даргын тушаалаар захиргааны хэм хэмжээний эрх зүйн акт болгон баталж, шалган нэвтрүүлэх журмыг хамгаалагч байгууллагатай хамтран тогтоож мөрдүүлэх үүрэгтэй ч хамгаалуулагч байгууллага төдийлөн оролцдоггүй нь харагдаж байна.

Шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд сахилга хариуцлага дэг журам зөрчигдөх, алба хаагчдын тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй байх. Объектын ажилчдын хууль эрх зүйн мэдлэг дутмаг байна.

Мөн Дотоодын цэргийн алба хаагч нь хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримтлан түүнд тулгуурлан шалган нэвтрүүлэх үйл ажиллагаагаа явуулах нь учирч болох сөрөг дагавраас урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ болох юм.

САНАЛ:

1. Алба хаагчдын харилцааны соёл ур чадвар, гадаад хэлний мэдлэг, паспорт болон viz-ны тухай ойлголт дутмаг байгаа тул тусгайлсан сургалт хөтөлбөр мэргэшүүлэн сургах.

2. Гадаадын иргэд улсын онц чухал объектод нэвтрэх ажиллах эрх зүйн орчинг сайжруулах.

3. Алба хаагч нарт нэг бүрчлэн үзлэг хийх нөхцөл бүрдүүлж, шалган нэвтрүүлэх цаг хугацаа хүн хүч, техник хэрэгслийг нэмэгдүүлэх.

4. Шалган нэвтрүүлэх бүртгэл судалгааг нарийвчлан хийж, илэрсэн зөрчилд дүн шинжилгээ судалгаа хийж, судалгааны үр дүнгээр дүгнэлт хийж цаашид шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд нэвтрүүлэх техник технологийн боломж, гарцыг танилцуулах, төсөв тооцоог хийх.

5. шалган нэвтрүүлэгч алба хаагчийн аюулгүй байдал хангагдахгүй эрсдэл үүсэж болзошгүй тул нэмэгдэл харуулчин буюу хосолсон манааг томилох, шалган нэвтрүүлэгч алба хаагчийг нэмэгдүүлэх,

6. Тогтоосон шалган нэвтрүүлэх журам үйл ажиллагаа, дэглэм, журмын хэрэгжилтийг дагаж мөрдөж байгаа байдалд, байгууллагын захиргаатай хамтран хяналт тавих, үүргийг хамгаалагч байгууллага хэрэгжүүлэх.

7. Шалган нэвтрүүлэх бүх төрлийн рентген төхөөрөмж, инженерийн техник, хэрэгслийг нэмэгдүүлэх, техник технологийн элэгдэл, хоцрогдлыг арилгах.

8. Хүн, тээврийн хэрэгсэл бүртгэх автомат бүртгэгч, төхөөрөмж ашиглаж, бүртгэлийн системийг төгөлдөржүүлж цахим хэлбэрт шилжүүлэн, алба хаагч зөвхөн үзлэг шалгалтыг чанартай өндөр түвшинд хийж албаны нохой ашиглах саналуудыг дэвшүүлж байна.

Ашигласан материалууд:

Нэг. Хууль тогтоомж, эрх зүйн актууд

1. Дотоодын цэргийн тухай хууль 2017 он
2. Цагдаагийн албаны тухай хууль 2017 он
3. ЦБҮАЖ-Дотоодын цэргийн үйл ажиллагааны журам
4. ДЦҮАЖ-Дотоодын цэргийн үйл ажиллагааны журам
5. Улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагааны стандарт

Хоёр. Ном сурах бичиг гарын авлага

1. Т.Хүрэлбаатар: Объектын хамгаалалтын зарим асуудал. 2007 он
2. Т.Хүрэлбаатар: Зорилт түүнийг хэрэгжүүлэх арга зам. 2003 он
3. Э.Рэгдэндагва: Улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн актын эмхэтгэл 2020 он

Гурав. Цахим эх сурвалж

1. <https://www.legalinfo.mn/>
2. <https://police.gov.mn/>